

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН
2025 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

Багануур дүүрэг

Гэрээний заалтын дугаар	Хариуцлагын гэрээнд туссан удирдах ажилтны хүлээх үүрэг	Биелэлт	Хувь
2.1.1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.1 болон 3.3.2 дахь, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 230, 231 дэх заалтуудад тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж улирал, хагас, бүтэн жилээр дүүрэг болон нийслэлд тайлагнан ажилласан.	100%
2.1.2	Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;	Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг тооцож хагас, бүтэн жилээр тайлагнан хүргүүлсэн.	100%
2.1.3	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах;	Төрийн албаны тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллаж, компанийн батлагдсан бүтэц орон тооны хүрээнд мерит зарчмыг баримтлан, удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан. Мөн албан хаагчдын ажилдаа хандах хандлага, ёс зүйг сайжруулах чиглэлээр 9 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, ёс зүйн сургалтыг хагас, бүтэн жилээр сургагч багшийг урьж 2 удаа танхимаар зохион байгуулсан.	100%
2.1.4	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний	2025 оны дүрмийн сангийн төсөв нийт 700.0 сая төгрөг: ■ Нийслэлийн ЗДТГ-т 2025.02.06-ны өдрийн 35 дугаар албан бичгээр НИТХ-ийн 2024 оны 24/33 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн сангийн хөрөнгө 600.0 сая төгрөгийн санхүүжилтийн олгох тухай хүсэлтийг хүргүүлсэн. Захирамжийн саналыг	100%

	биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	хуудсыг авч холбогдох удирдлагуудаар хянуулан баталгаажуулснаар 2025.02.14-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Санхүүжилтийг олгох тухай А/232 дугаар захирамж баталгаажсан. 2025.06.25-ны өдрийн 107 дугаар албан бичгээр нийслэлийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст 109,2 сая төгрөгийн төсвийг тодотголоор нэмүүлэх саналыг хүргүүлсэн. НИТХ-ын 2025 оны 25/106 дугаар тогтоолоор 100.0 сая төгрөг батлагдсан бөгөөд 2025.08.29-ны өдрийн А/1214 дугаар Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан. Компанийн санхүүгийн 2025 оны хагас жилийн тайлан гаргаж Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээр хянуулсан. Жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан хугацаанд нь тайлагнан ажиллана.	
2.1.5	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78, 79 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн төсөвт байгууллагын удирдлагатай байгуулсан “Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээ”, нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-гээр хүлээсэн үүргийг хангаж ажиллах;	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргатай Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар батлуулан гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажилласан.	100%
2.1.6	Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	Дэд станцын байршил өөрчлөгдсөн маргааныг шийдвэрлэхээр 2025.01.03-ны өдрийн 01 дугаар албан бичгээр “Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар”-т Месес ХХК-ийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар гомдол мэдээллийг хүргүүлсэн. Дүүргийн цагдаагийн хэлтсээс 2025.02.04-ны өдрийн 30к-3/682 дугаар албан бичгээр 140 дугаартай гомдол мэдээлэлд хууль ёсны төлөөлөгчөөр оролцох албан тушаалтныг томилох мэдэгдлийг өгсний дагуу 2025.02.12-ны өдрийн 40 дугаар албан бичгээр Б.Мичид-Эрдэнийг хууль ёсны төлөөлөгчөөр оролцох албан тушаалтнаар томилон мэдүүлэг өгүүлсэн.	100%

		- Тус хэрэг дүүргийн прокурорын газарт шилжиж хэрэгсэхгүй болсон. - Одоогийн байдлаар МЕСЕС ХХК-тай хамтран дэд станцын зураг төслийг шинэчлэхээр хамтран ажиллаж байна.	
2.1.7	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;	- Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76 км өндөр хүчдэлийн агаарын шугамын бүтээн байгуулалтын ажил 2022-2025 онуудад шилжин хэрэгжиж 2025.09.04-ний өдөр улсын комисс хүлээн авч бүрэн дууссан. - Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай дэд станцын ажлын гүйцэтгэгчээр “Эм Ай Эс Эс” ХХК шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан. Гэрээний дагуу ажил эхэлж байна. - Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг дүүргийн ерөнхий төлөвлөлттэй уялдуулан холбогдох дэд бүтцийн байгууллагууд болон дүүргийн менежертэй зөвшилцөн ажиллаж байна.	100%
2.1.8	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг шаардлагатай тохиолдолд Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	Дээд газраас ирсэн тогтоол, захирамж, албан даалгаврын хэрэгжилтүүдийг ханган ажиллаж тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	100%
2.1.9	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 37 дугаар тогтоолоор хаалттай хувьцаат компани болж компанийн хэлбэр өөрчлөгдөн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн компанийн дүрмийг бүхий л үйл ажиллагаанд мөрдлөг болгон тогтоосон хугацаанд чиг үүргийн хэрэгжилтийг тайлагнан ажилласан.	100%
2.1.10	төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх;	Компанийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2 жилийн хугацаатай хөтөлбөрийг батлан 2025 оны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Компанийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажилласан бөгөөд Ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр ирсэн комиссын гишүүдээс	100%

		Сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулан ажиллах чиглэл зөвлөмж өгсөн. - Нийт албан хаагчдын 2025 оны 07 сард “Эрт илрүүлэг” үзлэгт бүрэн хамруулсан. - Алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 13 компьютер, 5 принтер болон ширээ сандлыг бүрэн шинэчилсэн.	
2.1.11	Алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах	Компанийн Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын А/09 дугаараар шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан бүрэн хэрэгжүүлсэн. Албан хаагчдын хандлага, сахилга хариуцлага болон дүрэм, журмын талаарх дотоод сургалтуудыг тогтмол зохион байгуулан ажилласан.	100%
2.1.12	төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;	2025 оны 54, 99, 179 дугаартай албан бичгээр компанийн 1, 2, 3 дугаар улиралд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг хүргүүлсэн. 2025 оны 56, 172 дугаар албан бичгээр компанийн иргэд, аж ахуй нэгжтэй уулзсан тайлан мэдээг хүргүүлсэн. - Компанийн үндсэн үйл ажиллагаа болох нэгж, үйлдвэр элсүүлэх ажлын хүрээнд 18 байгууллагатай уулзалт зохион байгуулсан байна. Үүнээс байгууллагын цаашдын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн, паркийн нэгжээр орох хүсэлтэй байгаа аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, паркийн нэгжтэй холбоотой мэдээ мэдээллийг өгөн, 4 байгууллагатай санамж бичиг байгуулсан.	100%
2.1.13	холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;	Нийслэлийн дотоод аудитын албанаас 2025.03.31-ний өдөр 2/68 дугаар албан бичгээр 2023, 2024 оны дотоод аудит, хяналт шалгалтын тайланг ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, зөвлөмжийн тайланг 2025.06.10-ны өдөр цахимаар, 2025.06.25-ны өдрийн дотор албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Архивын газраас гаргасан хуваарийн дагуу 2025.10.17-ны өдөр Ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулагдсан улсын үзлэгийн бэлтгэлийг ханган ажиллаж, шалгуулсан.	100%

		Нийслэлийн төрийн аудитад 2024 оны санхүүгийн тайланг шалгуулсан бөгөөд зөрчилгүй санал дүгнэлт авсан.	
2.1.14	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах;	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулахад хотын хөгжлийн индекстэй уялдуулан боловсруулж саналыг хүргүүлсэн бөгөөд саналууд бүрэн тусгагдсан.	100%
2.1.15	Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох;	2025.03.12-ны өдрийн Хотын хөгжлийн индексийн тухай сургалтад 3 албан хаагч хамрагдсан.	100%
2.1.16	Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;	Манай компани нь хотын хөгжлийн 16, 29, 42, 48, 49, 51, 69, 71, 78 буюу нийт 9 индекстэй уялдан ажиллаж байна.	100%
2.1.17	Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;	Паркийн 2013 онд хийгдсэн Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан 22 үйлдвэрийн төслийг шинэчлэхээр зах зээлийн судалгаа болон эдийн засгийн тооцооллыг хийж, хэрэгжих боломжтойгоор эрэмбэлсэн. Паркийн Техник эдийн засгийн үндэслэлийг тодотгон боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан 3 байгууллагаас үнийн санал авсан бөгөөд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтээ уламжилсан. Техник эдийн засгийн үндэслэлийг тодотгон боловсруулах 400.0 сая төгрөгийн санхүүжилт Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний 327 дахь заалтад тусгагдаад байна.	100%
2.1.18	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал,	Тайлант хугацаанд албан хаагчаас ирүүлсэн өргөдлийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтлөн, өргөдөл болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн архивлахад бэлтгэв.	100%

	чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;	▪ Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна. ▪ 2025 оны 54, 99, 179 дугаартай албан бичгээр компанийн 1, 2, 3 дугаар улиралд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг хүргүүлсэн.	
2.1.19	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, Нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Нийслэлийн шуурхай хуралдаанд компанийн Гүйцэтгэх захирал тогтмол биечлэн оролцож, ирүүлсэн үүрэг чиглэл болон албан бичгийн хариуг шуурхай өгч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.	100%
2.1.20	Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Компанийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 бүлгийн 29 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. ▪ Эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт 73 хувьтай, ▪ 3 дугаар улирлын байдлаар хэрэгжилт 82,5 хувьтай, ▪ Жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 93 хувьтай байна.	93%
2.1.21	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг заасны дагуу байнга ил тод, нээлттэй байлгах 5 бүлгийн 87 төрлийн мэдээллийг shilen.gov.mn системд улирал бүр тайлагнан ажилласан. ○ 2025.06.30-нд хагас жилийн байдлаар тайлагнан 79 хувьтай, ○ 2025.09.30-нд 3 дугаар улирлын байдлаар тайлагнан 95 хувьтай, ○ 4 дүгээр улирлын биелэлтийг 2025.12.30-ны өдрөөс өмнө тайлан илгээхээр төлөвлөн ажиллаж байна.	100%
2.1.22	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;	Компанийн дүрмийн сангийн хөрөнгөөр 700.0 сая төгрөгийн төсөв батлуулсан. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол хэмнэлтийг барьж ажилласан. www.shilendans.mn сайтад хуулийн дагуу хугацаанд нь нийт <u>154</u> мэдээ, тайланг байршуулаад байна.	100%

2.1.23	Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй зөвшилцөж, уялдуулах;	- Японы эрчим хүч, хүрээлэн буй орчны салбарын утаанаас салах бодлогод чиглэсэн Монгол Улсад ирээдүйд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дэвшилтэт технологийн тухай, Монгол, Японы холбогдох талуудын хооронд харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжуудыг нээх зорилготой айлчлалын хөтөлбөрт дарга Ч.Элбэгсайхан томилолтоор ажилласан. - БНХАУ, БНСУ-ын томоохон компаниуд, хөрөнгө оруулагчдын мэдээллийг интернэт эх сурвалжаас түүвэрлэн, хэсэгчилж орчуулан, тойм мэдээлэл бэлтгэсэн. Холбоо барих мэдээллийг ашиглан хамтран ажиллах боломжийн талаарх товч мэдээллийг бэлтгэж, компанийн танилцуулгын хамт, дээрх компаниуд, хөрөнгө оруулагчдын холбоо барих хаяг руу буюу цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна. - Компанийн танилцуулгыг Монгол, Англи, Солонгос, Хятад хэл дээр бэлтгэн холбогдох сурталчилгаа, үйл ажиллагаанд ашиглаж байна. - БНСУ-ын үйлдвэрлэл, технологийн паркуудын хөгжсөн түүхийг интернэт эх сурвалжаас түүвэрлэн цуглуулж, орчуулж байна. - Компанийн үйл ажиллагааг хөгжүүлэн өргөжүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, мэдээлэл хүргэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, өндөр хөгжсөн үйлдвэрлэл, технологийн паркуудтай биечлэн танилцах, туршлага судлах хүрээнд төсөл, хөтөлбөрүүдэд оролцох боломжоор хангагдах, дэмжлэг туслалцаа авах хүсэлтийг Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, Нийслэлийн Засаг даргын Гадаадын хөрөнгө оруулалт хариуцсан орлогч С.Батырбек нарт хүргүүлсэн. - Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зарлан зохион байгуулдаг үзэсгэлэн, чуулга уулзалтуудын хуваарь, холбогдох мэдээллийг нэгтгэн гаргаж, дээрх арга хэмжээнүүдэд хамрагдах боломжийг эрэлхийлж байна.	100%
2.1.24	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг	100%

	хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;	дараах мэдээллийг хэрэгслүүдийг ашиглан байршуулж олон нийтэд хүргэсэн. ○ Компанийн албан ёсны веб сайт ○ 24tsag.mn ○ Ulaanbaatar.mn ○ Livetv.mn ○ Өдрийн сонин ■ Компанийн албан ёсны пэйж хуудсанд 3 дугаар улирлын байдлаар рийл-71, постер-55, фото мэдээ-341, нийт 352 удаа мэдээллийг байршуулсан. ■ erp.ulaanbaatar.mn цахим системд 9 удаа үйл ажиллагааг сурталчлан таниулах мэдээллийг байршуулсан. ■ http://baganuur-itp.mn/ сайтад дотоод үйл ажиллагаа-28, цаг үеийн мэдээлэл-46, сул ажлын байрны зар-6, хүний нөөцийн дүрэм, журам-9, алсын хараа, эрхэм зорилго-2, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан-38, паркийн танилцуулга-1, паркийн үндсэн нэгжүүдийн мэдээ-6, бүтэц, орон тоо-1, бодлогын баримт бичиг-6 нийт 126 удаагийн нийтлэлийг байршуулан ажилласан.	
Биелэлтийн хувь 99%			

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БЯМБАЦЭЦЭГ

